



МУБИС-ийн нийт багш, оюутнууддаа 2025-2026 оны хичээлийн жилийн мэндийг хүргэе!

Оюутны холбоо, зөвлөл, клубүүдийн маань үүд хаалга та бүхэнд ямагт нээлттэй байх болно гэдгийг онцлон тэмдэглэмээр байна. Энэхүү байгууллага шинэ үеийн залуусыг эгнээндээ нэгтгэсэн 26 жилийн түүхтэй бөгөөд энэ хугацаанд оюутны хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр тогтвортой ажилласаар ирсэн.

МУБИС-ийн оюутан байх нь зүгээр нэг нэр хаяг бус, харин хариуцлага, бахархал, эрхэм зорилго юм.

Та бүхэн бол шинэ үеийн төлөөлөл бөгөөд мэдлэг, боловсролоороо ирээдүйн залуу үеийг төлөвшүүлж, эрдэм мэдлэг түгээж, хүсэл тэмүүлээрээ нийгэмд өөрчлөлт авчрах чадамжтай хүчирхэг залуус билээ. Энэ сургуульд суралцаж буй оюутан бүрийн ард мөрөөдөл, зорилго, бас өөрчлөлт хийх хүсэл тэмүүлэл оршдог гэдэгт итгэлтэй байна.

Өнөөдөр зөвхөн суралцахаас гадна өөрийгөө бүхий л талаар хөгжүүлэх нь хамгийн чухал болсон цаг үе иржээ. Суралцагч танд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсье.

Хүндэтгэсэн,

Оюутны холбооны тэргүүн Д. Буянравжих

Товч танилцуулга:

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Оюутны холбоо нь оюутнуудыг эгнээндээ нэгтгэн, аливаа төр захиргааны байгууллагаас хараат бус, ашгийн бус, гишүүддээ үйлчилдэг

байгууллага юм. Анх 1998 онд Монголын Оюутны холбооны дэргэдэх Оюутны оролцооны бие даасан байгууллага болсон билээ. Өөрийн тамга тэмдэг, бэлгэдэл, туг, сүлд дуу, үнэмлэх, уриа, дуулал, өөрийн хэвлэмэл хуудастай бөгөөд удирдах зөвлөлийн хурлаар баталгаажсан журмын дагуу оюутныг шагнах дээд шагналтай.

МУБИС-ийн Оюутны холбоо нь Үндсэн хууль, МУБИС-ийн дүрэм журам, ТББ ийн тухай хууль тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Сургуулийнхаа нийт оюутан залуусын эрх ашгийг тууштай хамгаалж, тэдний хөгжил дэвшилд чиглэсэн хөгжлийн олон талт арга хэмжээг зохион байгуулахаас гадна сургуулийн захиргаа, оюутан залуусын дунд гүүр болон ажилласаар байгаа оюутны өөрийн удирдлагын байгууллага юм. Шаардлагатай үед бусад албан байгууллагуудтай хамтран ажиллах бүрэн бололцоотой бөгөөд өөрийн албан бланк, тамга тэмдэгтэй байгууллага юм.

МУБИС-ийн Оюутны холбооны тэргүүнээр Математик байгалийн ухааны сургуулийн – Биологийн багшийн 3-р курсийн оюутан Д.Буянравжих , дэд тэргүүнээр ДУТС-ийн Дизайн технологийн 4-р курсийн оюутан Г.Шинэбаяр , ерөнхий нарийн бичгийн даргаар БоСС-ийн нийгмийн ажил хүүхдийн арга зүйчийн 4-дугаар курсийн оюутан А.Оюунханд, хяналтын албаны даргаар БоСС нийгмийн ажлын 3-дугаар курсийн оюутан Б.Сэржмядаг , ажлын албаны даргаар ДУТС-ийн с3-р курсийн оюутан Л.Бүтэнбаяр нар ажиллаж байна.

МУБИС-ийн Оюутны холбооны бүтэц:

Удирдах зөвлөл

1. Хяналтын алба
2. Ажлын алба
3. Оюутны зөвлөл
4. Оюутны байрны нэгдсэн зөвлөл
5. Клубүүдийн нэгдсэн зөвлөл гэсэн салбар нэгжүүдээр үйл ажиллагаагаа зохион байгуулж байна.

МУБИС-ийн Оюутны холбооны Хяналтын алба

МУБИС-ийн ОХ нь Хяналтын зөвлөлтэй байх бөгөөд чуулганаас сонгогдсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Хяналтын зөвлөл нь / цаашид “Хяналтын зөвлөл” гэх/ ОХ-ны өөрийн хяналтын сонгуульт байгууллага бөгөөд Монгол улсын хууль тогтоомжийг удирдлага болгон энэхүү дүрмийн хүрээнд ОХ-ны үйл ажиллагаанд хяналтын үүргийг гүйцэтгэнэ. Хяналтын зөвлөл нь ОХ болон МУБИС-ийн удирдлага, бусад бүх шатны байгууллага, хувь хүнээс хараат бус байна. Хяналтын зөвлөлийн гишүүн нь ОХ-ны сонгуульт ажлыг хавсран хийх ёсгүй.

Хяналтын алба нь дараах бүрэн эрхтэй:

- ОХ-ны дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих, дүгнэлт хийх.
- ОХ-ны өмч хөрөнгийн ашиглалт, санхүүгийн ажиллагаанд хяналт, шалгалт хийх. үйл ажиллагааны талаар Удирдах зөвлөлийн хуралд мэдэгдэх.
- Хяналтын зөвлөл нь энэхүү дүрмийн хүрээнд өөрийн журам боловсруулан мөрдөж ажиллана.

Хяналтын алба нь дараах үүрэгтэй:

- Сар бүрийн эхэнд Оюутны зөвлөл, ажлын хэсгийн үйл ажиллагааны болон
- санхүүгийн тайлантай танилцаж дүгнэлт хийн “Тэргүүн”-д танилцуулах.
- Үйл ажиллагаа болон санхүүтэй холбоотой асуудлыг шаардлагатай тохиолдолд Удирдах зөвлөлөөр шийдвэрлүүлнэ.
- Бүрэлдэхүүн сургуулийн чуулганд хяналтын зөвлөлөөс төлөөлөн албан ёсоор хяналт тавьж оролцоно.

МУБИС-ийн бүрэлдэхүүний сургуулийн Оюутны зөвлөл:

МУБИС-ийн бүрэлдэхүүний сургуулийн оюутны зөвлөл нь / цаашид ОЗ гэх/ өөрийн сургуулийн оюутнуудын нийтлэг эрх ашиг сонирхлыг хамгаалж оюутнуудынхаа төлөө үйлчилдэг МУБИСОХ-ны нэгж байгууллага юм. Оюутны Зөвлөл нь өөрийн бэлгэдэл, туг, үнэмлэх, тэмдэг, хэвлэмэл хуудастай байж болно. Оюутны зөвлөл нь үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, зардлын тайланг зохих журмын дагуу холбогдох эрх бүхий байгууллагад тогтоогдсон хугацаанд гаргаж өгнө. Оюутны Зөвлөл нь жилийн ажлын төлөвлөгөө, төсвийн задаргааг санхүүгийн жилтэй уялдуулан гаргах бөгөөд өөрийн сургуулийн Сургалт эрдэм шинжилгээний хурлаар болон ОХ-ний тэргүүнээр батлуулна. Оюутны Зөвлөл нь МУБИСОХ-ны Удирдах Зөвлөлөөс баталсан дүрмийг мөрдлөгө болгон ажиллана.

МУБИС Оюутны байрны нэгдсэн зөвлөлийн дарга:

1. Э. Санчирмаа: СӨБС 2-р курс оюутан

МУБИС Клубүүдийн нэгдсэн зөвлөлийн дарга:

1. Л.Ивээл : БОСС Нийгмийн ажил 3-р курс оюутан

МУБИС Оюутны холбооны салбар зөвлөлүүдийн дарга нар:

1. Б.Шинэзул : Математик, Байгалийн ухааны сургуулийн Оюутны зөвлөлийн дарга
2. Улам-Оргих: Нийгэм, Хүмүүлэгийн ухааны сургуулийн Оюутны зөвлөлийн дарга
3. Э.Энхжин : Багшийн сургуулийн Оюутны зөвлөлийн дарга

4. Э.Орхон: Биеийн тамирын сургуулийн Оюутны зөвлөлийн дарга
5. Д.Нарангарвуу: Боловсрол судлалын сургуулийн Оюутны зөвлөлийн дарга
6. Б.Жамъянсүрэн: Дүрслэх, Урлаг Технологийн Сургуулийн Оюутны зөвлөлийн дарга
7. Э.Энхжин: Сургуулийн Өмнөх Боловсролын Сургуулийн Оюутны зөвлөлийн даргаар тус тус амжилттай ажиллаж байна.

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Оюутны холбооны

удирдах зөвлөлийн гишүүдийн утасны жагсаалт:

№	МУБИС-ийн оюутны холбооны гишүүд	Овог нэр	УТАСНЫ ДУГААР
1	ОХ-ны тэргүүн	Д.Буянравжих	86336933
2	ОХ-ны дэд тэргүүн	Г.Шинэбаяр	96362436
3	ОХ-ны НБ дарга	А.Оюунханд	80992596
4	Хяналтын албаны дарга	Б.Хишигсүрэн	89113188
5	Ажлын албаны дарга	Э.Нарангэрэл	80885800
6	Оюутны байрны нэгдсэн зөвлөлийн дарга	Э.Санчирмаа	96828988
7	НХУС-ОЗ-ийн дарга	Б. Улам-Оргих	90898840
8	БоСС-ОЗ-ийн дарга	Д.Нарангарвуу	94766124
9	БаС-ОЗ-ийн дарга	Э.Энхжин	88948764
10	ДУТС-ОЗ-ийн дарга	Б.Жамъянсүрэн	88513443
11	БТС-ОЗ-ийн дарга	Э.Орхон	99244162
12	СӨБС-ОЗ-ийн дарга	Э.Энхжин	85926628
13	МБУС-ОЗ-ийн дарга	Б. Шинэзул	90627711

МУБИС-ийн сургалтын үйл ажиллагаа, дотуур байр, сургуулийн орчинтой холбоотой санал хүсэлт, гомдолын Оюутны холбооны page-р дамжуулан өгөөрэй.

Оюутны холбооны facebook page хуудас: [\(3\) Facebook](#)